



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАТЛАВ.
САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ
/Албан тушаал/



А.ЭНХМАНЛАЙ
/Газрын үсгийн тайлал/

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УДИРДАМЖ

2026 оны 02 дугаар сарын 12

Дугаар 35-00/02

Улаанбаатар хот

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт
хийх тухай

Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл:

Удирдлагаас өгсөн үүргийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5² дугаар зүйлийн 5^{2.1} дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2026 оны Х/129 дугаартай "Хамтран ажиллах тухай" албан бичгийн дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд чөлөөт бүсэд эрх бүхий байгууллагын шийдвэрээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах эрх олгосон байдалд Төрийн хяналт шалгалтын тухай, Газрын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж санал дүгнэлт өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг арилгуулахад оршино.

Хоёр. Хяналт шалгалтын төрөл, хэлбэр:

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт.

Гурав. Хяналт шалгалтын арга:

Шалгалтаар Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэгдсэн байдал, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанд хадгалагдаж байгаа нэгж талбарын хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг (цахимаар) хянан үзэх, төрийн байгууллагуудаас баримт бичгийг гаргуулан авах, шаардлагатай тохиолдолд фото зураг авах зэргээр хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хяналт шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах хүн, хуулийн этгээд, объектын нэр:

Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба

Тав. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн:

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Салбарын хяналт шалгалтын хэлтсийн Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Т.Эрдэнэболор, Б.Туул, Э.Амаржаргал нар хийж гүйцэтгэнэ.

1535080005

Шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжилтэн (ахлах) нарыг татан оролцуулна.

Зургаа. Хяналт шалгалт эхлэх болон дуусах хугацаа:

Хяналт шалгалтыг 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэнэ.

Долоо. Хяналт шалгалтын чиглэл:

Дорноговь аймгийн Замын-Үүд чөлөөт бүсэд эрх бүхий этгээдийн шийдвэрээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах эрх олгосон байдал.

Найм. Хяналт шалгалтын дүнг танилцуулахтай холбоотой мэдээлэл:

Хяналт шалгалтын дүнг байгууллагын удирдлагад танилцуулж, улсын байцаагчийн эрх зүйн акт, баримт бичгийг гарган холбогдох газруудад хүргүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.

Ес. Өмнө хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээлэл:

Өмнө нь хяналт шалгалт хийж байгаагүй.

oOo